

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

**ЦАХИЛГААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт /
гэрээний нэр:
Тендер шалгаруулалт /
гэрээний дугаар:

*“Хил орчмын аялал жуулчлалын хөгжүүлэх зорилтын
хүрээнд эрчим хүчээр хангах ажил” ажил*
УТХ-01/2019

**Чойбалсан хот
2019 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019.07.23
Тендер шалгаруулалтын дугаар: УТХ-01/2019

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “Хил орчмын аялал жуулчлалын хөгжүүлэх зорилтын хүрээнд эрчим хүчээр хангах ажил” ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим **Төрийн худалдан авах ажиллагааны системээр зарлагдааж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын/ www.tender.gov.mn дээр байгаа/ дагуу зохион байгуулж байна.**

/Цахим тендерийн урилга 50,000 төгрөг/

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:

3.2.1 Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 35кВ-ын тусгай зөвшөөрөлтөй байх.

Борлуулалтын хэмжээ: **2017, 2018 оны** борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн **50%-аас** багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн төсөвт өртгийн **30 %-аас** багагүй байна.

Сүүлийн **2** жил буюу **2017, 2018 онд** ядаж нэг удаа тендерт санал болгож буй үнийн **50%-аас** багагүй дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Үнийн саналыг **2019 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2019 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн 10 цаг 10 минутад** нээнэ.

Орон нутгийн давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг,
Аймгийн ЗДТГ-ын 3 дугаар байрны 2 дугаар давхар.
Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар
Утас: 7058-3058
Факс: 7058-4058
Цахим шуудан: info@utmch.dd.gov.mn
Цахим хуудас: www.utmch.dd.gov.mn, www.tender.gov.mn**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, төсөв;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) ТШӨХ-т заасан бусад шаардлагатай мэдээлэл.
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТОӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвэл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	
ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 60,2 сая төгрөгийн төсөв өртөгтэй “Хил орчмын аялал жуулчлалын хөгжүүлэх зорилтын хүрээнд эрчим хүчээр хангах ажил” –д тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p>3.2.1 Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 35кВ-ын тусгай зөвшөөрөлтэй байх,</p> <ul style="list-style-type: none">• Гэрээг гүйцэтгэхэд дараах мэргэжилтэй ажилчид шаардлагатай бөгөөд үндсэн ажилтан байна. Нэг ажлын байранд нэг хүн санал болгоно. /сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын тооцооны хуудас, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, дипломын хуулбарыг хавсаргана/. Үүнд:• Цахилгааны инженер• Цахилгаанчин• Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны ажилтан• Бусад санал болгож буй мэргэжилтэн ажилтнууд <p>Дараахь үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Авто кран 5 тн• Ачааны авто машин• Өрөмдлөгийн машин• Бусад шаардлагатай тоног төхөөрөмж, баагаж хэрэгсэл <p>Тухайн ажил гүйцэтгэх үнийн саналыг дараахь мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баталгаажуулсан байх/• Борлуулалтын хэмжээ: 2017, 2018 оны борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50%-аас баагүй байна.• Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд төсөвт өртгийн үнийн 50 хувиас баагүй дүнтэй тухайн ажилтай ижил төстэй ажил ядаж нэг удаа гүйцэтгэсэн байх. /туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт/;• Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий

	<p>газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, • Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт, • Харилцагч банкны тодорхойлолт, • Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Төсөвт өртгийн дунгээс 30 хувиас багагүй байх /банкны тодорхойлолт, дансны үлдэгдэл/; • Тохижилтын ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, дүрмийг мөрдлөг болгох, ашиглагдах бараа, материал нь холбогдох чанарын шаардлага болон энэхүү тендерийн техникийн тодорхойлолтыг хангах тухай мэдэгдэл, • Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтооолын дагуу тохижилтын ажилд ашиглах Монгол улсын гарал үүсэлтэй бараа, материалын жагсаалт гаргаж ирүүлэх, • <p>Тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. Дурдсан мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТОӨЗ 2.1	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</p> <p style="text-align: center;">Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар Орон нутгийн өмчийн газар Утас: 7058-3058 Факс: 7058-4058 Цахим шуудан: info@utmch.dd.gov.mn Цахим хуудас: www.utmch.dd.gov.mn, www.tender.gov.mn Ш/Х-250</p>
ТОӨЗ 2.1	Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба оролцож байгаа тендерийн нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ.
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Mb-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Огноо: 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар:</p> <p style="text-align: center;">Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар Орон нутгийн өмчийн газрын хурлын өрөө</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: 2019 оны 08 дугаар сарын 05-ний өдөр</p>

	Цаг: <i>10 цаг 10 минут</i>
ТӨӨЗ 2.3	Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар баталсан журмын дагуу <i>давуу эрх тооцно</i> . Тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлт, нотлох баримт, холбогдох мэдээллийг тендерийн хамт ирүүлнэ.

Дөрөв. ЗУРАГ ТӨСӨВ

Хил орчмын аялал жуулчлалын хөгжүүлэх зорилтын хүрээнд эрчим хүчээр хангах ажилд уг тодорхойлолт хамарагдана.

Ажлын зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны техникийн дүрэм, улсын стандартыг мөрдөх ба БНБД 12-04-06 БНБД 12-03-04-г мөрдлөгө болгоно. Ажил гүйцэтгэх болон материал татан авалтын графикийг ирүүлэх хэрэгтэй.

Цахилгаан техникийн ажил

- БНБД 3.05.06-90 мөрдлөгө болгоно.
- БД 43-101-03 мөрдлөгө болгоно.
- 0,4 Kv ЦДАШ-ын тулгуур нь МЫЗ шаардлага хангасан УКШ-9.27.15 маягийн 9м өндөртэй тулгуур байна.
- ЦДАШ нь СИП-2А 3*35-1*54,6мм² утас байна.
- Тулгуурт СИП-2А утсын тогтоох арматур нь зэврэлтээс хамгаалагдсан хөнгөн цагаан хайлшаар хийгдсэн ҮIX^{^M}, ҮIXCP-1 маркийн баригч, салбарлагч, кронштейн байна.
- Нойлын утсыг газардуулагчид бэхлэхдээ газардуулагчийн салбарлагчаар газардалгын буултын утсанд холбоно.
- Тоолуурын хайрцаг Зш тоолуур багтах хэмжээтэй байхаар тооцон тулгуураас тоолууры э самбар хүртэл 4*10мм² утастай байна.
- 20кв хүртэл хүчдэлтэй агаарын шугамын утасны залгалтыг: Өнцгийн анкер тулгуурын хүзүүвчинд анкерын болон салбарлалтын шаантган хавчаараар шахалтын аргаар угсардаг гонзгой огтлолт холбогч хавчаараар гогцонд хэрэглэдэг нудрагатай хавчаараар, /халуун гагнууры э патрон хэрэглэж /өөр өөр төрлийн огтлолтой болон өөр өөр маркийн утаснуудын шахалтаар угсардаг аппаратын хавчаараар залгана.
- Алслалтын дунд гонзгой огтлолтой холбогчоор мушгих аргаар залган. Ганц судастай утсыг мушгих аргаар залган болно. Ганц судастай утсыг халуун гагнуураар залгаж болохгүй.
- Суурийн бүтээцэд зориулсан ухмалыг БНБД 3.02.01-90-ийн дагуу гүйцэтгэнэ.
- Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал сонгон худалдан авах тохиодолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрлэлийн материалыг сонгон авбал “Бүтээгдэхүүний тохиролын гэрчилгээ”, лабораторын шинжилгээний дүн, падаан хавсаргана. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүнг барилгын хувийн хэрэгт хавсарган. Цутгалтын ажлаас сорилын шоо цохих журмын адгуу авч лабораторын дүгнэлт гаргуулж байна. Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд

өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа 36 сарын баталгаа гаргаж өгнө. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагап бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ. Гүйцэтгэсэн ил, далд ажлыг акт, схем зураг, фото зургаар баталгаажуулж тухайн барилын захиалагчийн төлөөлөгч, барилгын улсын байцаагч, ашиглагчтай зөвшилцсөн байна. Дээрх техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчил эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

- Ажлыг улсын комисст хүлээлгэн өгөхдөө гүйцэтгэлийн зураг гаргаж өгөх

Тав. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

/Үнэлэгдсэн үе шатны хуваарь, төсөв бэлтгэхдээ ажлын тоо хэмжээг хяналтын төсвөөс авч тусгана уу. Төсвийг www.tender.gov.mn цахим хуудаст хавсаргсан болно./

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Нэргүй танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт засны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

9. Зөрчил, гологдол арилгах	9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
11. Үе шатны ажлын хуваарь	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
	В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ
11. Үе шатны ажлын хуваарь	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарыт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
13. Алданги	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарыт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
	Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ
14. Ажил дуусгах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гарана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гарана.
- 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>
ГЕН 2.1	<p>Ажил нь <i>[төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i>-аас бүрдэнэ.</p> <p>Ажлын талбай нь <i>[байришил]</i>-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.</p>
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
ГЕН 4.1	<p>Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i>⁴</p>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[моо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[моо]</i> хоног байна.
ГЕН 13.1	<p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.⁵</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.</p>
ГЕН 17.1	<p>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i>-ны дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i>-ны дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.</p>
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

Ес.ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

/...../ *ажлын үзүүлэлт*

Дугаар № /...../

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилсан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____
хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай,
_____ суурь, _____ хана, _____
хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар,
тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан,
цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад
ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын
_____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]